

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАГШИЙН АНГИЙН ОЮУТНУУДЫН ХӨГЖИЛД ХӨГЖИМ ТОГЛОХ ЧАДВАР НӨЛӨӨЛӨХ НЬ

Л.Цэрэннадмид¹

¹МУБИС-ийн Архангайн Багшийн сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Б.Оюунчимээ

Хураангуй

Багш боловсролын зорилго, агуулга нь СӨБ, бага дунд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулах, хэрэгцээ шаардлага, зах зээл дэх багшийн хөдөлмөрийн эрэлт, нийлүүлттэй баримжаалсан, багш бэлтгэх, нээлттэй уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх зорилтын хүрээнд багш бэлтгэх дээд сургуулийн оюутны чанар, чадавхи нь хамааралтай болж байна. Ямар учраас энэ асуудлыг хөндөх шаардлагатай болсон нь бэлтгэгдэн гарч байгаа багшийн чанартай холбоотой. Иймээс суралцагчдын хөгжмийн боловсролын мэдлэгт тулгуурлан, нотны мэдлэг, нот унших бичих чадвар, хөгжмийн өнгө тембрийг сонсож дагаж дуулах, хөгжимдөх, хоолойн дасгал зөв дуулах, амьсгалаа зөв хувиарлах, хөгжим тоглох арга барил, гоо сайхны мэдрэмж, танин мэдэхүйг хөгжүүлэх хөгжимдөх ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.

Түлхүүр үг: Даралтат хөгжим, хамтын ажиллагаа, хөгжмийн боловсрол

Судалгааны загвар хандлага

Оюутан нэг бүрийн хөгжмийн боловсролын мэдлэг чадварыг сайжруулах, сургалтын технологийг үр дүнтэй хэрэгжүүлэх, тэдний ур чадвар, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлж, судлан сайжруулсан судалгааг хийсэн.

Судалгааны үр дүн

Энэ хичээлийн судалгаагаар оюутан бүрийн хөгжмийн боловсролын түвшинг ахиулахын тулд хөгжмийн боловсролын мэдлэгийг, чадвар болгох, бодитоор биеэр үзүүлэх, хөгжим тоглох сонирхлыг нь нэмэгдүүлэх, хамтран тоглон туслан дэмжих, хөгжмийг тоглохдоо тухайн зохиолын утга агуулгад тохируулан темп, динамикийг зөв тохируулах, тоглох хэлбэр, хоёр гараар алдаагүй тоглох, нотны тухай мэдлэг, даралтат хөгжим дээрх нотны байрлалыг алдаагүй нэрлэж тоглох чадвар, дуулаад тоглох чадвар, өнгө тембрийг зөв сонгох чадварт суралцуулсан.

Практик ач холбогдол, шинэлэг тал

Даралтат хөгжмийг тоглож сурснаар оюутнууд дадлага хийх хугацаандаа хөгжмийн хичээл,

хөгжөөн баясгах үйл ажиллагаа, бусад урлаг уран сайнхы ажлыг зохион явуулах, түүнчлэн СӨБ-ын багш болж гараад заавал хөгжмийн багшийг харалгүй ангийн суралцагчдад хүүхдийн дуу тоглох бүрэн боломжтой болж байна.

СӨБ-ын багш болох оюутнуудад хөгжмийн боловсролыг мэдлэгийг чадвар болгон суралцах нь ирээдүйн багш боловсон хүчин болох тэр тусмаа цэцэрлэгийн багш хүнд байх хамгийн чухал чадвар болж байгаа юм.

Удиртгал

В.А. Сухомлинский “Хөгжим нь хүний сэтгэц, сэтгэлийн хөдөлгөөнийг шууд дамжуулдаг учраас, хүнд үгээр хэлэх боломжгүй утгыг хөгжмөөр дамжуулан хэлж болдог” гэжээ. Хөгжмийн зохиол бүтээл нь суралцагчдын бүтээлч сэтгэлгээ, бие даан сэтгэн бодох чадвар, үйл ажиллагааг хөгжүүлээд зогсохгүй, хүнийг тайвшруулж уярааж, хөгжмийн айзам хэмнэл, хөг аялгууг хүртэж мэдэрснээр хүн баярлах, гуних бахархах, ургуулан бодох, төсөөлөн илэрхийлэх гэх мэт сэтгэцийн бүхий л үйлдлийг хөгжмөөр авч байдаг. Урлагийн төрөл бүр утга санаа илэрхийлэх үндсэн хэрэгсэлтэй байдаг. Уран зохиолд үг хэллэг, уран зурагт өнгө будаг, театрт үг үйлдэл үндсэн хэрэгсэл нь болдог бол хөгжимд эгшиг буюу нот юм.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон үндэслэл: Хөгжмийн урлаг хөг, ая, айзам, хэмнэл нь бусад төрлөөс ялгагдах өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой үүнийг оюутны хөгжмийн боловсролын мэдлэгт тулгуурлан чадвар болгож оюутан нэг бүрийн хөгжилд багш хөгжмийн дур сонирхол төрүүлэх, хэрэглээ болгох талаар семинар, дадлага хичээлээр судлахын тулд энэхүү сэдвийг сонгосон болно.

Хичээлийн санаа: Би өөрөө бага ангийн багшаар ажиллах байгаад хөгжмийн багш болж хөрвөсөн. Хүн хөгжимд дур сонирхолтой, хөгжмийг хүртэн мэдэрч чадвал, хэрэглээ болгож болдог болохыг өөрийн биеэр баталсан. Ингээд хичээл заадаг оюутнуудад өөрийн мэргэжлийн сайхныг сурталчилах, хөгжимд дур сонирхолтой болгох үүднээс нөлөөлөх, хувийн туршлагадаа тулгуурлан энэхүү хичээлийг зааж туршсан юм. Хөгжим тоглож сурахад хамгийн чухал зүйл бол хөгжмийн онолын анхан шатны мэдэгдэхүүнтэй

байх. Үүнд: Нэн түрүүнд оюутнуудыг нот таних, унших, бичих чадвартай болгох зорилготой байсан.

Хичээлийн бэлтгэл судалгаа: МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын багшийн 1-р курсийн оюутнуудын хөгжмийн боловсролын мэдлэгийг судлах зорилгоор түвшин тогтоох шалгалтыг хийсэн. Судалгааг хөгжмийн анхан шатны мэдэгдэхүүний хүрээнд асуулга бөглөх байдлаар авсан. Энэ нь оюутны хөгжмийн боловсролын мэдлэг чадвар, өмнөх ЕБС-ийн үзсэн хөгжмийн онолыг хэр байгааг харуулж чадсан судалгаа болсон. Судалгаанд үндэслэн нот мэдэхгүйгээр хөгжим тоглож сурах нь учир дутагдалтай болохыг харуулахыг зорьсон. Судалгаанд хөгжмийн анхан шатны мэдэгдэхүүнийг шалгах асуултуудыг ашигласан.

Хөгжмийн онолын анхан шатны мэдэгдэхүүн шалгах асуулт:

- Хөгжмийн ямар эгшгийг G үсгээр тэмдэглэдэг вэ?
- Эгшгүүдийн урт, богины ялгааг хөгжмийн гэнэ.
- Дараах тэмдэглэгээг нэрлэ.
 - а. tr.....
 - б. f
- Дөрөвт нот хэдэн тоонд дуулагддаг вэ?
- Дэвсгэр шугамд нотыг зөв байрлуулж бичээрэй.
- Эгшгүүдийг уруудах дараалалаар бичээрэй.
- 2/4 хэмнэлд 6 такт нот бичээрэй.
- Нотны дэвтэрт ми-бемоль, ля-бемоль, си-бемоль, фа-диез, ре-бекарыг бичих
- Темп, динамик гэсэн үг нь юу гэсэн үг вэ? тайлбарлан бичээрэй.

Судалгааг 2020-2021 оны хичээлийн жилийн 9 сард авсан.

Судалгааны үр дүн: Сургуулийн өмнөх боловсролын багшийн 1-р курсийн оюутнуудын хөгжмийн боловсролын мэдлэг, чадварын түвшнийг дээрх шалгуур үзүүлэлтээр авч үзсэн. Судалгаанаас харахад оюутнуудын хөгжмийн анхан шатны мэдэгдэхүүн, мэдлэг, чадвар хангалтгүй байгаа нь харагдсан. Энэ нь цаашид хөгжмийн боловсрол, хүүхдийн дуу хөгжим, хөгжим заах арга зүй хичээлүүдийг ороход учир дутагдалтай хэмээн дүгнэсэн.

- Хөгжмийн онолыг анхан шатнаас нь системтэй заах төлөвлөлт хийх
- Дэвсгэр шугамд соль түлхүүр, үндсэн 7 эгшгийг өдөр бүр 1 нүүр бичих даалгавар
- Бүтэн, хагас, дөрөвт, наймт, арванзургаат нотуудыг ялгах, таних дасгал даалгавар хийх
- Нотыг 2/4, 3/4, 4/4 хэмнэлээр тактлах дасгал хийлгэх
- Хэмнэлээр алга таших, тогших дасгал хийлгэх
- Нотоор хэмнэлийн чээж бичиг хийлгэх
- Даралтат хөгжимд байрлах 7 эгшгийн

байрлалыг тогтоох, нүдлүүлэх

- 7 эгшгийн гамм уншуулах

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл: /Мэдлэг бүтээлгэх/

Оюутнуудын судалгааны үр дүнд үндэслэн эхний семинар хичээлээр багш нот, дэвсгэр шугам, түлхүүр гэж юу болох, түүнийг хэрхэн тэмдэглэдэг болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч хялбар дасгал ажилуулав. Оюутнууд дэвсгэр шугамыг яагаад хэрэглэдэг болох, хаанаас нь эхэлж дугаарладаг эсэх, соль түлхүүрийг яагаад “Соль” гэж нэрлэдэг болох, ямар үүрэгтэй болох, дэвсгэр шугамд 7 эгшгийг хэрхэн зөв байрлуулдаг болох, нотны бүтэц задаргааг ойлгож нотоор бодлого бодох, нотыг унших, бичих талаар ойлголтой болсон. Нотыг уншиж, бичиж, таньж сурснаар хөгжим тоглож болдогийг

Үг. З.Александрова, ая М.Красева “Гацуурхан” дууны жишээгээр үзүүлсэн. Оюутнууд нотыг



Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага:

Хөгжмийн боловсрол хичээлээр оюутнуудын эзэмших тусгай чадварыг хангахад оюутнуудын хөгжим тоглох чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж, ганцаарчлан, хэсэг бүлгээр ажиллах, гамм уншуулах, дасгал ажил хийлгэх, хөгжимдөх дасгалыг өдөр бүр хичээлийн бус цагаар тогтмол хийлгэж ажилласан. Багш хичээлийн алхам тутамд оюутнуудтай хамтран тэдэнд туслагч, зөвлөгч, чиглүүлэгч дэмжигч нь байж хөгжим тоглох арга зүйг туршлага болгон хэрэгжүүлнэ.

Судалгааны үр дүн

Оюутнуудад даралтат хөгжмийг тоглож сургах явцдаа хичээлийн алхам бүрд алдаа дутагдлыг засч, зааварлаж зааж сургах нь оюутнуудын хөгжим сурах идэвх сонирхол өрнөж, дуулж хөгжимдөж хичээлд хандах хандлага өөрчлөгдөж, зарим оюутнуудыг хөгжмийн багшаар хөрвөж, ажиллах дур сонирхолтой болгож чадсан юм. Оюутнууд дадлагад гарахдаа бүлгийн хүүхдүүдэд хөгжим дарж дуу дуулуулах, хөгжим тоглож сонирхуулах, оюутан байх хугацаандаа хөгжмийн цагийн багшаар ажиллах хүртэл үр дүнд хүрсэн.

Судалгаат хичээлээр хийсэн зарим нэг сайжруулалт

- Хичээлийг оюутны өөрийн мэдлэг, чадварын түвшинд тохируулан заасан.
- Оюутан нэг бүртээ ганцаарчлан ажилласан
- Ангийн системийг хөгжмийн нөөц бололцоондоо тулгуурлан групп хэлбэрээр орсон. Энэ нь хүүхэд бүр хөгжим дээр ганцаараа ажиллах нөхцөл бүрдэж үр дүн сайжирсан.
- Хичээлийн бусад цагаар хөгжмийн лаборатори ангид оюутнуудыг хөгжим дээр тоглуулж давуулах болсон.

- Даралтат хөгжмийн дугуйланг Мягмар гарагийг 15⁰⁰ цагт хийдэг болсон.

Хөгжмийн боловсрол хичээлээр хөгжмийн анхан шатны мэдэгдэхүүн хичээлийг СӨБ-ын 1а, б ангиудад хөгжим тоглож сургах бэлтгэл ажлын хүрээнд хэд хэдэн үе шаттай Суралцахуйн судалгаа (learning study) хийж ээлжит хичээлийг зохион явуулсан. Үүнд

Нэгдүгээр хичээл: Хөгжмийн эгшиг

- Оюутны хөгжмийн боловсролын талаарх өмнөх мэдлэгийг үнэлэх
- Ярилцлага хийх /ЕБС-д хөгжмийн онолын талаарх мэдлэгийг хэрхэн олж авсан тухай/
- Хөгжмийн онолын мэдлэгээр түвшин тогтоох шалгалт /судалгаа хийх/
- “Хөгжмийн боловсрол” хичээлийн хөгжмийн анхан шатны ухагдахуун хичээлийг заана.
- Шалгалтанд бичсэн зүйлтэй нийцэж буй эсэхийг ярилцана.

Хоёрдугаар хичээл: Бататгал хичээл

- Хөгжмийн анхан шатны ухагдахуунууд болох Дэвсгэр шугам, нот соль тулхүүр, нотны задаргаа дахин заана.
- Дэвтэрт тэмдэглэл хийхийг багш сануулна. Шинэ нэр томъёог багш тайлбарлаж өгнө.
- Хичээлээс хэцүү зүйлийг дахин тайлбарлаж, жишээн дээр дахин тайлбарлана.
- Хялбар дасгал, даалгавар ажиллуулж анализ хийнэ.

Гуравдугаар хичээл: Туршилт хичээл

- Хөгжмийн онолын мэдлэгээ бататган даралтат хөгжимд үндсэн 7 эгшгийн байрлалыг заасан.
- Дэвсгэр шугамд байрлах нотыг хөгжимд хэрхэн тоглох талаар тайлбар хийж, хөгжим дээр дадлага хийлгэнэ.
- Алдаа, дутагдлыг харж үнэлэлт дүгнэлт хийнэ.
- Ололт амжилтыг бататгана. Цаашид хөгжим тоглох арга зүйтэй болно.

Хичээлийг СӨБ 1а,б ангид зааж туршиж үзэхэд оюутны нот чээжлэх, таних, унших, бичих байдал дээшилсэн мөн хялбар хүүхдийн дууны нотыг харж тоглох чавдар сайжирч байгаа нь илт мэдрэгдэж байлаа. Үүнээс үзэхэд онолын хичээлийг дадлага хичээлтэй хамтатган илүү цагаар хичээллэх нь илүү үр дүнтэй болох нь харагдлаа. Оюутан зөвхөн хичээлийн 7 хоногийн 1 цагт ороод л байх нь дараагийн 7 хоногт орох хүртэл өмнөх мэдлэгийг мартах хэмжээнд хүрч байна. Тиймээс илүү цагаар хичээллэх нь үр дүн сайтай байх болсон.

Ном зүй

1. Батсүх, Б., Батжаргал, Ж. (1991). Дуу хөгжим заах арга зүй. Улаанбаатар.
2. Ганболд, Г., (2003). Монголын хөгжмийн зохиолчдын бүтээл дэх дуунууд. Улаанбаатар
3. Лхагвасүрэн, Ж. (1986). Цэцэрлэгийн хүүхдэд хөгжмийн хүмүүжил олгох арга зүй. Улаанбаатар.
4. Оюунбилэг, Ч. (2006). Хөгжмийн боловсрол олгох арга зүй. Улаанбаатар.
5. Пүрэвдорж, Ч. (он т-бус). Багшлахуйн менежмент. Улаанбаатар.
6. Пүрэвсүрэн, Д., Чимэдлхам, Ц. (2000). Дуу хөгжим хичээлийн технологийн шинэчлэл. Улаанбаатар